



2012 оны 11 сарын 30
(5-р хэвлэл)

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ И-СОНИН

Монголын хөрөнгийн зах зээлд нэвтрүүлсэн “Миллениум Ай Ти” системд нэмэлт функциуд амжилттай суурилууллаа.

Мэдээний тойм:

- Монголын хөрөнгийн зах зээлд нэвтрүүлсэн “Миллениум Ай Ти” системд нэмэлт функциуд суурилууллаа.
- Зах зээлийн мэдээ
- Монголын хөрөнгийн зах зээлд нэвтрүүлсэн “Миллениум Ай Ти” системийг ашиглагч орнуудын тоо нэмэгдсээр байна.
- 2012 оны 11-р сарын 26-нд “Эдийн засгийн хэлэлцүүлэг: Монголд хөрөнгө оруулах тухай” дугуй ширээний уулзалт Хонг-Конгд болж өндөрлөлөө.
- Бүртгэлтэй компаниудын мэдээ

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК, Төрийн өмчийн хороо, Лондонгийн хөрөнгийн бирж группын хооронд байгуулсан “Ажлын мастер гэрээ”-ний дагуу МХБ-д “Миллениум Ай Ти” системийг 2012 оны 7-р сарын 2-ны өдөр суурилуулсан бөгөөд шаардлагатай нэмэлт функциудыг тодорхой үе шаттайгаар суурилуулахаар гэрээнд тусгасан билээ. Уг гэрээний дагуу шаардлагатай нэмэлт функциудын сургалт, туршилтыг 2012 оны 11-р сарын 5-ны өдрөөс 2012 оны 11-р сарын 9-ний хооронд зохион байгуулсны үндсэн дээр, 2012 оны 11-р сарын 19-ний өдрөөс эхлэн албан ёсоор ашиглалтанд орууллаа.

Системд дараах нэмэлт функциудыг суурилуулаад байна. Үүнд:

- Бонд болон богино хугацааны өрийн бичгийн хоёрдогч зах зээлийн цогц шийдэл
- Хүүгийн төлбөр тооцоо, эргэн төлөлтийн тооцоо

- ‘All or None’ /Бүгдийг нь эсвэл алийг нь ч биш/ захиалга – Худалдан авахаар эсвэл худалдахаар оруулсан захиалгыг нэг удаагийн хэлцлээр бүгдийг нь биелүүлэх эсвэл огт биелүүлэхгүй байх захиалгын аргачлал юм.

- “Маркет мэйкинг” – энэ нь аливаа үнэт цаасыг худалдан авах эсвэл худалдах захиалгыг давхар өгч, үнэт цаасыг худалдан авах эсвэл худалдах захиалгууд орвол түүнийг заавал биелүүлэх байдлаар “зах зээлийг бий болгох” арга юм.


- Оффлайн захиалга – Энэ нь үнэт цаасны худалдан авах эсвэл худалдах захиалгыг урьдаас файлаар бэлдэн оруулах аргачлал юм.

- Бусад жижиг функциуд

Эдгээр нэмэлт функциудыг суурилуулснаар МХБ-ийн харилцагчид, брокер, дилерүүд нь олон улсын хэмжээнд ашиглагддаг арилжааны олон төрлийн, дэвшилтэт аргачлалуудыг ашиглах боломжтой боллоо.

Зах зээлийн мэдээ

TOP-20 индексийн үзүүлэлт /сүүлийн 2 долоо хоногт/



Монголын хөрөнгийн бирж

2 долоо хоногийн:

Арилжигдсан ширхэг 253.3 мянга
Арилжигдсан дүн 165.8 сая.төг
Арилжигдсан компанийн тоо 61

Хамгийн их өсөлттэй:

Хүнс Архангай /НАН/ +32.2%
Улаанбаатар БУК /БУК/ +15.0%
Хөдөөгийн тээвэр /НУТ/ +15.0%

Хамгийн их бууралттай:

Хасу мандал /HSR/ -24.4%
Могойн гол /BDL/ -24.1%
Мон асар /ASA/ -15.0%

2012 оны 11 сарын 19-нөөс 2012 оны 11 сарын 30-ны хооронд нийт 9 удаагийн арилжаа явагдаж, 61 компанийн 165.8 сая төгрөгийн үнийн дүн бүхий 253.3 мянган ширхэг хувьцаа арилжсан байна.

Уг хугацаанд хамгийн идэвхтэй арилжигдсан компани нь ‘Тавантолгой’ ХК /48.6 сая.төг/, ‘Баянгол зочид буудал’ ХК /15.2 сая.төг/, ‘АПУ’ ХК /8.8 сая.төг/ байсан байна.

Зах зээлийн үнэлгээ:

1,588.7 тэрбум.төг

TOP-20 индексийн өөрчлөлт:

15,126.72 / -2.00%

Индекс:

TOP-20

Вебсайт:

www.mse.mn

2012 оны 11 сарын 30
(5-р хэвлэл)



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ И-СОНИН

Монголын хөрөнгийн зах зээлд нэвтрүүлсэн “Миллениум Ай Ти” системийг ашиглагч орнуудын тоо нэмэгдсээр байна.

Монголын хөрөнгийн зах зээлд нэвтрүүлсэн арилжаа, төлбөр тооцоо, хадгаламж, хяналтын цогц шийдэл бүхий “Миллениум Ай Ти” системийг дэлхийн 20 гаруй орны 30 гаруй хөрөнгийн бирж, санхүүгийн байгууллагууд ашигладаг билээ.

Тус системийг ашиглагч орнуудын тоо нэмэгдсээр байгаа бөгөөд Норвеги Улсын Ослогийн хөрөнгийн бирж “Миллениум Ай Ти” системийг амжилттай суурилуулан, 2012 оны 11 дүгээр сарын 22-ноос эхлэн арилжаандаа ашиглаж эхлээд байгаа тухай Лондонгийн хөрөнгийн бирж группын охин компани “Миллениум Ай Ти” компаниас мэдээллэсэн билээ.

Мөн Хонг-Конгийн хөрөнгийн биржийн Orion central gateway платформд “Миллениум Ай Ти” компанийн “Миллениум COP” системийг нэвтрүүлэх гэрээг 2012 оны 11-р сарын 15-нд байгуулсан байна.

Orion central gateway нь Хонг-Конгийн хөрөнгийн биржид одоогийн хэрэглэж буй технологийг орлон нэвтрүүлэхээр зэхэж буй платформ бөгөөд энэхүү платформдоо тохирох системийг сонгохдоо олон улсын хэмжээний систем ханган нийлүүлэгчдийг өндөр шалгууруудаар харьцуулан үзсэний эцэст, маш өндөр хурдтай, хүчин чадал сайтай бөгөөд үр ашигтай гэж үзсэний үндсэн дээр “Миллениум Ай Ти” системийг

сонгосон тухай Хонг-Конгийн хөрөнгийн биржийн “Системийн хөгжил, стратегийн газар”-ын тэргүүн дэд ерөнхийлөгч Жулиан Раглесс мэдээлсэн байна.

Лондонгийн хөрөнгийн биржийн Глобал хөгжлийн газрын захирал, “Миллениум Ай Ти” компанийн гүйцэтгэх захирал Тони Версинг дэлхийн хөрөнгийн зах зээлд тэргүүлэгч Хонг-Конгийн хөрөнгийн бирж нь “Миллениум Ай Ти” системийг сонгосон нь манай систем бүтэц, хүчин чадлаараа шилдэг болохыг дахин баталгаажуулсан хэрэг боллоо хэмээв.

2012 оны 11-р сарын 26-нд “Эдийн засгийн хэлэлцүүлэг: Монголд хөрөнгө оруулах тухай” дугуй ширээний уулзалт Хонг-Конгд болж өнгөрлөө.

Монголын жижиг, дунд бизнес, стратегийн ач холбогдол бүхий төсөл, бүтээн байгуулалтад шаардлагатай хөрөнгө оруулалтыг татах үүднээс Хонг-Конг, Макао дахь Монгол Улсын консулын газар, Хонг-Конгийн хөрөнгө оруулалтын газар, Хонг-Конгийн хөрөнгийн бирж, Худалдааг дэмжих зөвлөл, Монголын хөрөнгийн бирж хамтарсан “Эдийн засгийн хэлэлцүүлэг: Монголд хөрөнгө оруулах нь” сэдэвт дугуй ширээний уулзалт 2012 оны 11-р

сарын 26-ны өдөр буюу Монгол Улс тунхагласны 88 жилийн ойн баярын өдрөөр Хонг-Конгд болж өнгөрлөө.



Энэхүү дугуй ширээний уулзалтын үеэр Монголын төрийн байгууллагууд болон компаниуд Хонг-Конгийн банк, санхүүгийн байгууллага, хөрөнгө оруулагчидтай уулзалт хийж, бизнесийн төсөл, саналаа танилцуулан, хамтын ажиллагаагаа өргөжүүлэх талаар яриа хэлэлцээр өрнүүлсэн ач холбогдол бүхий арга хэмжээ болж өндөрлөө.

“Азия пасифик пропертис” ХК-ийн үнэт цаасны арилжааг сэргээлээ

“Азия пасифик пропертис” ХК-ийн үнэт цаасны үнэ ханш нь тогтмол өссөнтэй холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооноос шалгалт хийж, улсын байцаагчийн 2011 оны 12-р сарын 23-ны өдрийн 112 тоот албан

шаардлагаар үнэт цаасны арилжааг түр зогсоож, холбогдох үүрэг даалгаврыг хүргүүлээд байсан.

Санхүүгийн зохицуулах хорооноос өгсөн үүрэг даалгавар биелэгдсэн гэж үзэн “Азия пасифик пропертис” ХК-

ийн үнэт цаасны арилжааг 2012 оны 11-р сарын 26-ны өдрөөс эхлэн сэргээхээр шийдвэрлэсэн байна.